

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ

Н.ХОНГОРЗУЛ

ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ

## Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн их засварын ажил

**4-р багц: Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үүдний хэсэг, коридор, шатны хонгил, АЦӨ-ний хэсэгчилсэн засварын ажил**

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Сургуулийн барилгын Спорт зал, урлаг зал, гал тогооны засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулж ирүүлэх

Г.Үнийн саналд зураг төслийн үнийг **78 833 000** төг тусган ирүүлэх ба “Барилгын төсөв зохиох дүрэм” БНБД 81-95-12\*(2020)-г мөрдлөг болгоно.

Д. Барилгын их засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

### 1. Задалж буулгах ажил

Сургуулийн барилгын коридор, вестибюль, шатны хонгилын хуучин будагтай хана, багана, таазны гадаргууг хусаж цэвэрлэнэ. Тааз, хаалга, цонхны хөндийрч суларсан шаврыг хусаж цэвэрлэх. Ариун цэврийн өрөөний плита, хуучин хулдаасыг хуулж цэвэрлэх. Шаазан жорлон, тосгуур холигчийн хамт, шаазан угаагуур буулгах бөгөөд цаашид ашиглах боломжтой материалыг сургуулийн удирдлагуудад актаар хүлээлгэн өгнө. Буулгалтын ажлын явцад барилгаас гарсан хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт асгана.

1-р давхарын багш нарын өрөөний хамар ханыг буулгах /С10, С11/. 1-р давхарын цонхны хайрцаг задалж шавардлага хуулна. /В2/. 3-р давхарын радио узелийн өрөө, хооллох өрөө, кино проекцийн өрөө, нийгмийн ажилтны өрөө, хонгил

/С11,12,13,14, D3, А8/ өрөөнүүдийн хана, таазны гадаргууг хусаж цэвэрлэх. 3-р давхарын радио узелийн өрөө, хооллох өрөө, кино проекцийн өрөө, нийгмийн ажилтаны өрөө, хонгил /С11,12,13,14, D3, А8/ өрөөнүүдийн шалны хуучин хулдаас линолеум хуулах.

Буулгалтын ажил гүйцэтгэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана.

## **2. Хана, хамар хана, өрөгт бүтээцийн ажил:**

1-р давхарын багш нарын өрөөний хамар ханын өргийг өрөх /C10,C11/. Хамар ханыг 75 маркийн 1800 кг/м<sup>3</sup> нягттай ердийн улаан тоосгоор өрнө. Хамар ханын өргийн босоо чиглэлд 675мм тутамд бүх уртынх нь дагууд торлож өгнө. Өрөгт цементэн зуурмаг хэрэглэх бөгөөд тоосгон өргийг 50 маркын зуурмагаар гагнаж өрнө.

Цонх тоосгоор битүүлж өрөх /B2/. Барилгын гадна ханыг 350мм зузаантай дүүргэгч хана тоосгоор өрж гадна талаас нь шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах. Дүүргэгч ханыг 75 маркийн 1800 кг/м<sup>3</sup> нягттай ердийн улаан тоосгоор өрнө. Хамар ханын өргийн босоо чиглэлд 675мм тутамд бүх уртынх нь дагууд торлож өгнө. Өрөгт цементэн зуурмаг хэрэглэх бөгөөд тоосгон өргийг 50 маркын зуурмагаар гагнаж өрнө.

Зөвхөн өрөг, шавардлагын зуурмагыг барилгын талбайд бэлтгэхийг зөвшөөрөх ба зуурмагт орох элс, хайрга, цемент зэргийг мөн лабораторид шинжлүүлж шаардлагад нийцэх эсэхийг тогтоосны дараа зуурмагийг бэлтгэнэ.

## **3. Хаалга, цонхны ажил:**

- Барилгын гол орцны гонхонд байрлах давхар шилэн ханануудын хаалганы доод хүрээг тэргэнцэртэй хүн явах шаардлагад нийцүүлэн 2см-с их зөрүү үүсгэхгүй хийнэ. Хичээллэх анги танхимын хаалга 2 хавтастай, хатаалттай, лактай, шилэн гэгээвчтэй байна. Хичээллэх анги танхимын хаалга 1 хавтастай, хатаалттай, будагтай, шилэн гэгээвчтэй байна. Барилгын дотор хаалга нь 2 хос нугастай, цоож, нугас, бариулууд нь сайн чанарын төмрөөр хийгдсэн, сайн чанарын бүрэн хатаалттай сайн чанарын модон хаалга байна.

- 3-р давхарт өрөөг хонгилоос тусгаарлах шилэн ханыг доороо тоосгон өрлөггүй хийнэ. Шилэн хана нь металл рамтай хатжуулсан шилтэй хаалгатай шилэн хана угсарна /A8/.

- Гадна хаалга ган төмөр хавтастай, эрдэс хөвөн дулаалган тусгаарлагчтай өвлийн улиралд цантаж мөстөхгүй, дотогш хүйтэн дамжуулахгүй байх шаардлагатай.

- Хаалга цонхыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай бат бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай. Хаалга, цонхыг захиалахдаа барилгын ажлын явц дууссаны дараа газар дээрээс бодит хэмжээг дахин авах шаардлагатай. Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийнэ.



#### 4. Шалны ажил:

- Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД– 81-11-06 мөрдлөг болгоно.  
- Ариун цэврийн өрөөнд бетоны дэвсгэр үе хийнэ БМ100. Бетон шаланд 20 мм зузаан бетон тэгшилгээ хийн, уур ус тусгаарлагч хийнэ. Цементэн зуурмагаар плитан хавтанцар наана.

- 3-р давхарын радио узелийн өрөө, хооллох өрөө, кони проекцийн өрөө, нийгмийн ажилтаны өрөө, хонгил /С11,12,13,14, D3, А8/ өрөөнүүдийн шаланд 20мм зузаан цементэн тэгшилгээ хийн, хүйтэн түрхлэг дээр хулдаас наана. 3-р давхарын /А8/ өрөөнд сайн чанарын дрозж наах.

#### 5. Дотор заслын ажил:

- Дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шиллэгээ, өнгөлгөөний ажилд БНБД 31-10-05-г мөрдөнө. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна

- Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Барилгын коридор, вестибюл, шатны хонгилын таазанд тэгшилгээ хийж сайн чанарын цагаан эмульсэн будгаар будна. Ариун цэврийн өрөөний таазанд тэгшилгээ хийж, ус чийгэнд тэсвэртэй сайн чанарын эмульсэн будгаар будна.

- Дотор ханын гадаргуунд шаварын засварын цементэн шохойн зуурмагаар шавардаж тэгшилгээ хийнэ. Дотор ханыг h=2м хүртэл өнгийн тосон будгаар гараар сайн чанартай будна. Дотор ханын h=2м дээш хэсгийг сайн чанарын эмульсэн будгаар будна. Ариун цэврийн өрөөний хананд плита наах шавардлага хийн, 450x300 мм-ийн хэмжээтэй өнгөлгөөний плитан хавтанцар шалнаас тааз хүртэл наана. Ариун цэврийн өрөөний ханыг бэлэн өнгөлгөөтэй модон хийцээр угсарна.

- Шатны налууг шавардаж тэгшилгээ хийн сайн чанарын эмульсэн будгаар будна. Шатны хайс хашлагыг өнгийн тосон будгаар будна.

- 1-р давхарын цонх тоосгоор битүүлж өрөх /В2/. Гадна ханыг шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах. Дотор ханыг шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах. Хананд тэгшилгээ хийж өнгийн тосон будгаар будах. 3-р давхарын радио узелийн өрөө, хооллох өрөө, кони проекцийн өрөө, нийгмийн ажилтаны өрөө, хонгил /С11,12,13,14, D3, А8/ өрөөнүүдийн ханын гадаргууг шохойн зуурмагаар шавардаж тэгшилгээ хийн, өнгийн тосон будагаар гараар сайн чанартай будна. 3-р давхарын радио узелийн өрөө, хооллох өрөө, кони проекцийн өрөө, нийгмийн ажилтаны өрөө, хонгил /С11,12,13,14, D3, А8/ өрөөнүүдийн таазанд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будна.

- Хаалга цонхны амалгааг шавардаж тэгшилэн сайн чанарын эмульсэн будгаар будна.



- Барилгын дотор заслалын ажилд дэлхийн эрүүл мэндийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн, лабораторын шинжилгээ хийгдсэн материал хэрэглэж, бичиг баримтыг объектын хувийн хэрэгт хавсаргана.

- Өрөө тасалгааны өнгөний сонголтыг хийхдээ захиалагч, ашиглагч байгууллагатай харилцан зөвшилцөх шаардлагатай.

### **7. Дотор цэвэр, бохир усны ажил**

- Одоо ашиглаж байгаа шаазан угаагуур, суултуурыг эвдэж гэмтээхгүйгээр салгаж өрөөний дотор заслал хийгдсэний дараа буцааж угсрана /Ариун цэврийн өрөө, спорт заал, гал тогоо/. 8 ш ханын ганцаарчилсан почкитэй хөтөвчийг шинээр угсарна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг шинээр төлөвлөж тоноглолыг суурилуулна.

#### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**  
АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА



/Ц.МӨНХ-ЭРДЭНЭ/

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**  
АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА



/Ц.БАЯРМАА/